



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/246

Ховд

Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуулийн
хэрэгжилтийг хангуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах, хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ) ашиглах үйл ажиллагааг зогсоох, хэрэглэгчийн хурууны хээ уншигч төхөөрөмжүүд агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгах ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн

- | | | |
|---------|--------------|--|
| Ахлагч: | Н.Тэгшжаргал | - Тагнуулын ерөнхий газрын Ховд аймаг дахь газрын дарга |
| Гишүүд: | Г.Ганжаргал | - Мэдээлэл холбооны сүлжээ төрийн өмчит компанийн Ховд аймаг дахь газрын дарга |
| | Э.Ганбаяр | - Тагнуулын ерөнхий газрын Ховд аймаг дахь газрын ажилтан |
| | Ч.Эрдэнэбат | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | Д.Дөмөгтүшиг | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн |
| | Ж.Батбаяр | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Боловсрол, шинжлэх ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | Д.Батнасан | - Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтэн |
| | М.Өнөрмаа | - Хүний эрхийн үндэсний комиссын Ховд аймаг дахь ахлах шинжээч |

2. Хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл, хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ) ашиглах үйл ажиллагааг зогсоох, хэрэглэгчийн хурууны хээ уншигч төхөөрөмжүүд болон дуудаж ажилладаг сервисийг зогсоох, техникийн мэдээлэл, хурууны хээ агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгах ажлыг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд үүрэг чиглэл өгч 2022 оны 05 дугаарын сарын 02-ны өдрийн дотор хариуцан зохион байгуулж тайлагнахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг заасан хугацаанд удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, ажлын явц, үр дүн, хэрэгжилтэд 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хяналт тавьж тайлагнахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч Тагнуулын ерөнхий газрын Ховд аймаг дахь газрын дарга (Н.Тэгшжаргал)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай.

ДАРГА  

Б.ДҮГЭРЖАВ